

**ГЕОДЕЗИ, ЗУРАГ ЗҮЙН САЛБАРЫН АЖИЛТНЫ МЭРГЭЖИЛ
ДЭЭШЛҮҮЛЭХ СУРГАЛТ ЗОХИОН БАЙГУУЛАХ ЖУРАМ**



Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Ажилтны мэргэжил дээшлүүлэх сургалт зохион байгуулах журам /цаашид "журам" гэнэ/ нь сургалтын өөрийн дотоод үйл ажиллагааг зохион байгуулахтай холбогдолтой үүсэх харилцааг зохицуулах баримт бичиг мөн.

1.2. Геодези, зураг зүйн салбарын мэргэжилтнүүдийн мэдлэг, мэргэшлийг орчин үеийн чиг хандлагад нийцүүлэн тасралтгүй дээшлүүлэх, онолын мэдлэг, практикийн дадлага олгох замаар давтан сургах, мэргэшлийн ур чадварын төвшин, өрсөлдөх чадварыг дээшлүүлэх, бүтээл, туршлагыг үнэлэхэд энэхүү журмын зорилго оршино.

1.3. Сургалт зохион байгуулагч (МГФ33Х), сургалтанд хамрагдагч (мэргэжилтэн) нарын хоорондын харилцааг МГФ33 Холбооны дүрмийн 2.2.4, БХБ Сайдын 2017 оны 200 дугаар тушаалаар баталсан "Барилгын салбарын ажилтны давтан сургалт, мэргэшлийн зэрэг олгох дүрэм"-ийг үндэслэн энэ журмын дагуу шийдвэрлэнэ.

1.4. Журмыг Сургалтыг зохион байгуулагч, мэргэжилтэн нар (цаашид талууд гэх) дагаж мөрдөнө.

1.5. Журмын хэрэгжилтэд оролцогч талууд хяналт тавина.

**Хоёр. Мэргэжилтэн зэрэг горилох, сунгах, ахиулаад
тавигдах шаардлага**

2.1. Зэрэг горилох, сунгах, ахиулах мэргэжилтнүүд БХБ Сайдын 2017 оны 200 дугаар тушаалаар баталсан "Барилгын салбарын ажилтны давтан сургалт, мэргэшлийн зэрэг олгох дүрэм"-ийг нэгдүгээр хавсралтад заасан шаардлага хангасан байх.

2.2. Мэргэшсэн зэрэг горилох мэргэжилтэн нь сургалтын хэлбэрээр 10 багц цагийг хангасан байх. Үүнээс сургалтын хэлбэрээр заавал суралцах 5 багц цаг, сонгон суралцах 5 багц цаг суралцсан байх.

2.3. Мэргэшсэн зэрэг сунгах мэргэжилтэн нь зэргийн хүчинтэй хугацаандаа 15 багц цагийг хангасан байна. Үүнээс сургалтын хэлбэрээр 10 багц цагийг (заавал суралцах 5 багц, сонгон суралцах 5 багц), бие даасан хэлбэрээр 5 багц цаг хангасан байх.

2.4. Зөвлөх зэрэг горилох мэргэжилтэн нь мэргэшсэн зэрэг нь хугацаагүй эрхтэй болсноос хойш 3 жилийн хугацаанд заавал суралцах сургалтын 3 багц цагийг хангасан байх. Хэрэв хугацаа нь 3-аас дээш жил болсон тохиолдолд 15 багц цагийг хангасан байх. Үүнээс сургалтын хэлбэрээр заавал суралцах 5 багц цаг, сонгон суралцах 5 багц цаг, бие даасан хэлбэрээр 5 багц цагийг бүрдүүлсэн байх.

2.5. Зөвлөх зэрэг сунгах мэргэжилтэн зэргийн хүчинтэй хугацаандаа 15 багц цагийг хангасан байх. Үүнээс сургалтын хэлбэрээр заавал суралцах 3 багц цаг, сонгон суралцах 2 багц цаг, бие даасан хэлбэрээр 10 багц цагийг бүрдүүлсэн байх.

2.6. Зэрэг сунгах, ахиулах мэргэжилтнүүд бие даасан хэлбэрээр суралцах багц цагаа хангасан байх ба бие дааж суралцсан цагаа Сургалт зохион байгуулагчаар багц тооцуулсан байх.

Гурав. Сургалтад хамрагдах хүсэлт гаргах

3.1. Мэргэжилтэн салбарын ажилтны мэргэшлийн зэргийн багц цагийн сургалтанд хамрагдах хүсэлтээ 12 дугаар сарын 15-ны дотор Сургалт зохион байгуулагчид гаргана.

3.2. Багц цагийн сургалтад хамрагдах хүмүүс дор дурдсан материалыг нүхтэй хавтсанд хийж, сургалт эхлэхээс 3 хоногийн өмнө ирүүлнэ. Үүнд:

- Анкет /Сургалтын анкетыг компьютерт шивж гаргана/
- Иргэний үнэмлэх, нийгмийн даатгалын дэвтрийн хуулбар
- 3*4 хэмжээтэй 2% цээж зураг
- Дээд боловсролын үнэмлэх, дипломын хуулбар
- Төлбөрийн баримт
- Сургалт зохион байгуулагчаас олгосон багц цаг тооцсон сургалтын гэрчилгээ
- Зэрэг сунгах, ахиулах мэргэжилтнүүд зэргийн гэрчилгээгээ эх хувиар
- Мэргэшлийн зэрэг горилох, сунгах мэргэжилтэн энэхүү журмын 2.1-д заасныг бүтээлийн тайлангаа “Барилгын салбарын ажилтны давтан сургалт, мэргэшлийн зэрэг олгох дүрэм” загвар 1-ийн дагуу заалт нэг бүрийг хангасан талаарх мэдээлэл буюу холбогдох материал

3.3. Мэргэшлийн зэрэг горилох, сунгах мэргэжилтэн нь мэргэжил дээшлүүлсэн тайлангаа “Барилгын салбарын ажилтны давтан сургалт, мэргэшлийн зэрэг олгох дүрэм”- загвар 2-ийн дагуу сургалт зохион байгуулагч байгууллагаар баталгаажуулж багц цаг тооцуулсан байна.

3.4. Сонгон суралцах сургалтад хамрагдах мэргэжилтэн нь сургалт эхлэхээс 7 хоногийн өмнө багц цагийн сэдвийн сонголтыг батлагдсан сургалтын сэдвээс сонгож зохион байгуулагчид ирүүлнэ.

Дөрөв. Сургалтын багц цаг тооцох

4.1. Мэргэшлийн зэргийн сургалтыг заавал, сонгон суралцах хэлбэрээр сурах хэлбэрээр зохион байгуулна. Сургалтын багтаамжийг багц цагаар хэмжинэ.

4.2. Сургалтын хэлбэрээр багц цагийг тооцохдоо 8 цагийн хичээлийг мэргэжил дээшлүүлэх сургалтын 1 багц цаг, дадлага сургалтын 16-аас доошгүй цагийн хичээлийг сургалтын 1 багц цаг гэж тооцно. Нэг цагийн хичээлийн үргэлжлэх хугацаа нь 45 мин байна.

4.3. Бие даасан хэлбэрээр багц цагийг тооцохдоо дараах зарчмыг баримтална:

- 4.3.1. УИХ-д өргөн мэдүүлсэн хуулийн төслийг боловсруулах ажлын хэсэгт эрх бүхий этгээдийн шийдвэрээр томилогдон ажилласан бол 2 багц цаг
- 4.3.2. хуулийг дагалдан гарах дүрэм, журам, бодлогын бичиг баримтыг боловсруулж батлуулсан, захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн санд бүртгэгдсэн бол 4 багц цаг
- 4.3.3. салбарын чиглэлээр норм, дүрэм, стандартын төсөл боловсруулах ажлын хэсэгт орж ажилласан ба тухайн бичиг баримт батлагдсан бол 4 багц цаг
- 4.3.4. гарын авлага, мэргэжлийн ном, нэг сэдэвт бүтээл зохиож нийтлүүлсэн бол 4 багц цаг
- 4.3.5. мэргэжлийн болон асуудал дэвшүүлсэн эрдэм шинжилгээний өгүүлэл /дотоод, гадаадад/ нийтлүүлсэн бол 1 багц цаг
- 4.3.6. тухайн жилд магистрын зэрэг хамгаалсан, хамгаалсан сэдвийн чиглэл нь мэргэжлийн хүрээнд нийцсэн бол 4 багц цаг
- 4.3.7. тухайн жилд докторын (phd) зэрэг хамгаалсан, хамгаалсан сэдвийн чиглэл нь мэргэжлийн хүрээнд нийцсэн бол 8 багц цаг

- 4.3.8. салбарын чиглэлээр төсөл, хөтөлбөр боловсруулж батлуулсан, түүнд оролцсон бол 1 багц цаг
- 4.3.9. сургалтын хөтөлбөр боловсруулсан, мэргэжил дээшлүүлэх сургалтад багшаар оролцон хичээл заасан бол хичээлийн 4 цаг тутамд 1 багц цаг
- 4.3.10. бакалавр, магистрант оюутны төгсөлтийн ажлын удирдагчаар ажиллаж амжилттай хамгаалуулсан тохиолдолд төгсөлтийн ажлыг хамгаалсан тушаалыг нь үндэслэн 2 багц цаг,
- 4.3.11. бакалавр, магистрант оюутны төгсөлтийн ажлын зөвлөхөөр ажиллаж оюутан төгсөлтийн ажлаа амжилттай хамгаалсан тохиолдолд төгсөлтийн ажлыг хамгаалсан тушаалыг үндэслэн 1 багц цаг,
- 4.3.12. оюутны эрдэм шинжилгээний ажлын удирдагчаар ажиллаж, илтгэл хэлэлцүүлсэн эсвэл өгүүлэл нийтлүүлсэн тохиолдолд нотлох материалыг үндэслэн 1 багц цаг,
- 4.3.13. хурал, зөвлөгөөнд тавьсан илтгэлийг /дотоодын, олон улсын/ хөтөлбөрийг үндэслэн 1 багц цаг

4.4. Сонгон суралцах хичээлийн сэдэв, агуулга, заах багшиг сургалт хариуцсан зөвлөл урьдчилан тодорхойлж, тухай бүр сургалтын төлөвлөгөө боловсруулан батлуулж, нийтэд мэдээлнэ

4.5. Сонгон суралцах хичээлийн багц цагийн багтаамж нь заавал суралцах багц цагийнхтай адил байна.

4.6. Мэргэжилтэн нь сонгон суралцах хичээлийн төрөл, сургалтад хамрагдах хугацааг хэсэгчилсэн буюу өөрийн хэрэгцээ сонирхолд нийцсэн байдлаар сонгож болох ба дүрэмд заасан хугацаанд багтаан сонгон суралцах нийт багц цагийг хангасан байна.

Тав. Шалгалт

5.1. Заавал суралцах багц цагийн сургалтыг зохион байгуулсны дараа шалгалт авах ба сонгон суралцах сургалтыг шалгалтгүй зохион байгуулна.

5.2. Шалгалтад боловсролын стандартаар хүлээн зөвшөөрөгдсөн тестиийн аргыг хэрэглэнэ.

5.3. Шалгалтыг батлагдсан сургалтын сэдэвчилсэн төлөвлөгөөний дагуу сэдэв тус бүрээр авна.

5.4. Сонгосон багц цагийн хичээлийн ирц 75 хувиас доошгүй тохиолдолд багц цагийн шалгалтад орох эрхтэй болно.

5.5. Багшийн шалгалтад авбал зохих нийт онооны 75 ба түүнээс дээш хувийг авбал тэнцсэнд тооцно.

5.6. Шалгалтын тест, асуултын тойм, хүрээг шалгуулагчдад шалгалтын өмнө урьдчилан танилцуулсан байна.

5.7. Шалгуулагч тухайн сэдвийн шалгалтад тэнцээгүй тохиолдолд дараагийн шалгаруулалтад орох өргөдлөө өгч зөвхөн тухайн сэдвийн шалгалттай холбогдсон төлбөрөө төлөөд шалгалтад орж болно.

Зургаа. Сургалтын төлбөр

6.1. Заавал суралцах сургалтын багц цагийн төлбөрийг тооцоходоо Барилга, хот байгуулалтын яамны төрийн нарийн бичгийн даргын 2018 оны 07 дугаар сарын 05-ны өдөр батлагдсан “Төлбөрийг хэмжээг батлах” тухай А/125 дугаар тушаалыг баримтална.

6.2. Холбооны гишүүн байгууллагын мэргэжилтэн болон гишүүн мэргэжилтний сургалтын төлбөрийг 20 хувь хөнгөлнө.

6.3. Сургалтын төлбөрийн хэмжээг суралцагчийн тооноос хамааруулан хөнгөлөлттэй тогтоож, Холбооны Тэргүүнээр батлуулна.

6.4. Сонгон суралцах сургалтын төлбөрийг суралцагчдын тооноос хамаарч тогтоох ба “Төлбөрийг хэмжээг батлах” тухай А/125 дугаар тушаалыг баталсан тарифаас 20 хүртэл хувиар хөнгөлнө.

6.5. Сонгосон багц цагийн дагуу сургалтын төлбөрийг Голомт банк 1205001580 МГФЗЗХ ТББ дансанд сургалт эхлэхээс 3 хоногийн өмнө тушаана.

Долоо. Талуудын эрх, үүрэг

- 7.1. Холбоо нь дараах эрх, үүрэгтэй ажиллана.
- 7.1.1. тухайн онолын хичээлийг урт хугацаанд тогтвортой заах нөхцөлийг хангасан байхаар багш нартай тохиролцож ажиллах. Ингэхдээ нэг хичээлийг багадаа 2 багш (нэг багш нь нөөц байдлаар ажиллах) заадаг байхаар сонгох.
- 7.1.2. багш нарын зааж байгаа хичээлийн агуулга, төвшин нь сургалтын батлагдсан төлөвлөгөөтэй нийцэж буй эсэхэд хяналт тавих,
- 7.1.3. гүйцэтгэх захирал сургалт зохион байгуулах бүрд сургалтын менежерийг сонгон гэрээ байгуулж ажиллуулах, сургалтын менежерийн цалинг холбооны тэргүүнтэй зөвшилцэн тогтоох,
- 7.1.4. сургалт зохион байгуулах анги, танхимыг олох, түрээслэх, гэрээ байгуулах,
- 7.1.5. сургалтад ашиглах проектор, бичгийн хэрэгсэлээр багш нарыг хангах,
- 7.1.6. багш нарын цалинг сургалтад хамрагдсан мэргэжилтнүүдийн тооноос хамааруулан тогтоох, олгох
- 7.1.7. сургалт дууссаны дараа энэ дүрмийн 5-д заасны дагуу шалгалт зохион байгуулах,
- 7.1.8. шалгалтад тэнцсэн мэргэжилтнүүдэд холбогдох багц цагийг хангасан тухай батламж гэрчилгээ олгох,
- 7.1.9. сургалт зохион байгуулсан тухай тайланг холбогдох материалын хамт Барилгын нэгдсэн холбоонд хүргүүлэх,
- 7.1.10. мэргэшлийн зэрэг бүхий мэргэжилтнүүдийн бүртгэл хөтлөх, мэдээллийн сан үүсгэх,
- 7.1.11. мэргэжилтнүүдэд мэргэшлийн зэргээ сунгуулах, ахиулах хугацаа болж байгаа болон шаардлагатай багц цагаа хангах сургалтад хамрагдах тухай мэдэгдэх,
- 7.1.12. сонгон суралцах сургалтыг зохион байгуулах сонирхолтой иргэн, байгууллагатай гэрээ байгуулан хамтран ажиллах ба сургалтын хүрээ, шаардлагыг хангасан сэдэвт нь багц тооцсон гэрчилгээ олгоно.
- 7.2. Сургалтын менежер нь дараах үүрэгтэй ажиллана.
- 7.2.1. сургалтанд хамрагдаж байгаа мэргэжилтнүүдийн болон хичээл зааж байгаа багш нарын ирцийн бүртгэлийг хөтлөх,
- 7.2.2. багш нарын бэлтгэж ирсэн сургалтын материалыг суралцагчдын тоогоор олшруулж түгээх,
- 7.2.3. сургалтад ашиглаж буй тоног төхөөрөмж, хичээлийн байрны эд хөрөнгийн бүрэн бүтэн байдлыг сургалт зохион байгуулагдах хугацаанд хариуцах,
- 7.2.4. сургалтын төгсгөлд багшийн заах арга, сэдвийн агуулга, сургалтын үр дүнгийн талаар тусгайлан бэлтгэсэн загварын дагуу мэргэжилтнүүдээр санал асуулга авах.
- 7.2.5. холбооны санхүүгээс сургалтын үед хэрэглэх бичгийн хэрэгсэл, материалыг авах, сургалт дууссаны дараа тооцоо нийлэх,
- 7.3. Хичээл заах багш дараах үүрэгтэй ажиллана.
- 7.3.1. Мэргэшлийн зэрэг горилох, сунгах төвшин бүрд тохирсон, агуулгын хувьд төвшин ахисан байдлаар заах хичээлээ бэлтгэх,

- 7.3.2. хичээл эхлэхээс өмнө өөрийн заах хичээлийн материалыг хэвлэмэл байдлаар нэг хувь бэлтгэж, сургалтын менежерт өгөх,
 - 7.3.3. сургалтын төлөвлөгөөнд заасан хугацаанд хичээлээ үр дүнтэй заах,
 - 7.3.4. заавал суралцах сургалт дууссаны дараа өөрийн заасан хичээлийн агуулгаар өмнө нь бэлтгэсэнтэй агуулгын хувьд давхардаагүй, шалгалтын тестийг хариултын хамт бэлтгэж өгөх,
- 7.4. Мэргэшлийн зэрэг горилох, сунгах мэргэжилтний эрх, үүрэг
- 7.4.1. зэргийн хүчинтэй хугацаанд батлагдсан сургалтын төлөвлөсөнд заасан хичээлүүдээс зөвхөн өөрт сонирхолтой, шаардлагатай хичээлийг сонгон суралцах,
 - 7.4.2. сургалтын төлөвлөгөөнд болон агуулга сайжруулах тухай санал өгөх,
 - 7.4.3. багш нарыг үнэлэх,
 - 7.4.4. сургалтын материалыг хэвлэмэл байдлаар шаардаж авах,
 - 7.4.5. танхимын бусаар багц цаг хангасан тухайгаа нотлох баримтын үндсэн дээр холбоогоор баталгаажуулж авах,
 - 7.4.6. зэргийн хүчинтэй хугацаандаа сургалтын төлөвлөгөөний шаардлагатай багц цаг хангах сургалтад хамрагдах,
 - 7.4.7. сургалтын төлбөрөө заасан хугацаанд төлөх,
 - 7.4.8. Сонгон суралцсан сургалтад хамрагдсан цагаараа багц цаг авах эрхтэй

2019 оны 4-р сарын 12.